

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д шаардлагатай
 шууд худалдан авалтын зар №70

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/20260601764
 Төсөвт өртөг: 18,000,000 төгрөг

2026.04.01

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	ХН	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Төмөртолгой уурхайн ариутгал халдваргүйжүүлэлт угаалга хийлгэх, ариутгал хийх төхөөрөмж суулгах	багц	1	Төмөртолгой уурхайн засварын байрны 750 м2 хэмжээтэй, 20 м өндөр ханатай, ган краказ бүхий сэндвичээр барьсан барилгын цэвэрлэгээ ариутгал хийх.

Халдваргүйжүүлэлт ариутгал хийх тагтаа устгах төхөөрөмж суулгах ажлын даалгавар

1	Захиалагч байгууллага	“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
2	Захиалагч байгууллагын хаяг	Үйлдвэрийн район, Дархан сум, Дархан-Уул аймаг Хонгор сум
3	Засварын байр цэвэрлэх, ариутгах ажлын үндэслэл	<p>1. Засварын байранд тагтаа үүрлэж сангасаар байрны хийцлэл бохирдсон нь дараах эрсдэлүүдийг үзүүлж байна.</p> <p>Эрүүл мэндийн эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> • 60 гаруй төрлийн нян, вирус тээдэг • Сангас (ялгадас) нь фосфорын хүчил болон хүчиллэг бодис агуулдаг тул арьсны харшил, нүдний өвчин үүсгэх эрсдэлтэй • Өдөнд нь хачиг, бүүрэг, шимэгч хорхой агуулагддаг тул амьсгалын замын өвчин тараах магадлалтай <p>Ажлын орчны бохирдол</p> <ul style="list-style-type: none"> • Засварын орчинд тагтаа байнга буух нь тоосжилт, бохирдол, халдварын эрсдэл нэмэгдүүлдэг.
4	Зорилго, хэрэгцээ шаардлага	Төмөртолгой уурхайн засварын байрны хана таазыг цэвэрлэж ариутгах, шувуу тагтаа үргээгч төхөөрөмж суурилуулж дуу чимээ гаргаж дайжуулах
5	Байршил	Дархан Уул аймаг Хонгор сум Төмөртолгой уурхай
6	Засварын байрны хэмжээ	750 м2 хэмжээтэй, 20 м өндөр ханатай, Ган карказ бүхий сэндвичээр барьсан барилга.

7	Засварын байр цэвэрлэх ариутгах, төхөөрөмж суулгах ажилд тавигдах үндсэн шаардлага	Засварын байрны ган карказ, хана, тааз, цонх бүрэн цэвэрлэж, ариутгах <ul style="list-style-type: none"> • Засварын байрны шувууны үүр сангасыг цэвэрлэж зайлуулах • Бүх талбайг халдваргүйжүүлэх • 4 ширхэг тагтаа дайжуулах төхөөрөмж суурилуулах
8	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх хүчинтэй хугацаа бүхий тусгай зөвшөөрөлтэй байх • Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/406 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-д заагдсаны дагуу мэргэжлийн багийн бүрэлдэхүүнтэй, тоног төхөөрөмж, техникийн хэрэгслээр бүрэн хангагдсан үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байх • Байгаль орчин аялал жуулчлал, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр, Эрүүл мэндийн 3 сайдын хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан бодисын нөөцийг бүрдүүлсэн байх. Ашиглах бодисын жагсаалтыг ирүүлнэ. • Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм мөрдөж ажиллах. • Шувуу үргээгч төхөөрөмж
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн хугацаанд багтаан захиалагч талд ажлыг хүлээлгэн өгөх

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг Ажил гүйцэтгэсэн тайлан, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт, нэхэмжлэхийг үндэслэн төлбөрийг 30 хоногийн дотор төлнө.
- Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх хүчинтэй хугацаа бүхий тусгай зөвшөөрөлтэй байх

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, нийлүүлэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт
- Нийлүүлэх барааны үзүүлэлт, танилцуулга, бусад нотлох баримт
- Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл хаяг, утасны дугаар

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

**Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах мэйл хаяг:**

procurement2@dmp.mn

Утас/факс: 7509-0044